

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХҮН АМ

Баянгол дүүрэгт 2018 оны 01-р сарын 01-ний бадлаар 103561 эрэгтэй, 117823 эмэгтэй буюу нийт 221384 хүн байнга оршин сууж байна. Энэ нь Улаанбаатар хотын нийт хүн амын 15.6 хувь нь байгаа юм.

Хүснэгт 1. Суурин хүн амын тоо, хороогоор, 2010-2017

Хороо	2012	2013	2014	2015	2016	2017
Дүүргийн дүн	192 615	200 163	208 898	205 663	214 278	221 384
1	15 643	16 858	17 800	17 380	17 259	17 597
2	7 884	8 124	8 185	7 941	8 381	8 467
3	7 157	7 160	8 594	9 357	11 326	13 546
4	12 155	13 283	15 930	17 000	17 896	19 212
5	8 265	8 407	10 010	9 443	10 200	10 540
6	14 846	15 331	15 631	16 027	16 176	16 507
7	10 291	11 565	11 817	11 367	12 456	12 582
8	11 091	11 303	11 618	11 303	12 188	12 072
9	6 119	6 068	6 143	6 557	7 204	7 061
10	8 123	8 484	8 568	8 413	8 550	8 583
11	6 427	6 539	6 791	6 624	6 692	7 072
12	10 598	11 312	11 728	10 677	10 426	11 050
13	4 202	4 427	4 384	4 252	4 490	4 607
14	4 658	4 845	4 761	4 321	4 423	4 324
15	4 615	4 613	4 592	4 280	4 514	4 699
16	7 843	7 809	7 638	6 774	6 715	6 580
17	8 370	8 879	9 275	9 195	8 823	9 214
18	9 530	9 298	10 232	10 750	11 182	11 867
19	6 021	6 211	5 917	5 724	6 025	6 340
20	7 487	7 825	7 881	7 219	7 833	7 944
21	8 084	8 159	8 065	7 396	7 617	7 681
22	7 585	7 774	7 569	8 030	8 172	8 156
23	5 621	5 889	5 769	5 633	5 730	5 683

Дүүргийн суурин хүн амын тоо өмнөх оноос 7.1 хүнээр (3.3%) өсчээ. Хүн амын нягтралаар авч үзвэл: Баянгол дүүргийн 1км² нутаг дэвсгэрт 2012 онд 6529, 2013 онд 6785, 2017 онд 7504 хүн оршин сууж байна.

Зураг 1. Дүүргийн хүн амын өсөлт



Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг сүүлийн 7 жилийн байдлаар авч үзвэл 2010 онд 5.5 хувь, 2011 онд 3.6 хувь, 2012 онд 0.3 хувь, 2013 онд 3.8 хувь, 2014 онд 4.2 хувь, 2016 онд 4.0 хувь, 2017 онд 3.2 хувиар тус тус өсөж, 2015 онд 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Жилийн эцсийн суурин хүн ам

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017
Жилийн эхний хүн ам	192 614	200 163	208 898	205 663	214 278	221 384
Төрсөн хүүхэд	5 002	5 371	5 826	5 716	5 769	6 065
Нас барсан хүн	1 006		1 008	984	949	1 086
Шилжин ирсэн хүн	10 707	14 892	15 315	15 309	12 992	17 430
Шилжин явсан хүн	9 588	12 443	12 674	12 505	10 967	15 068

Хүн амын өсөлт нь төрөлт нас баралтын зөрүүгээр тодорхойлогдох ердийн цэвэр өсөлт, шилжин ирэлт, шилжин явалтын зөрүүгээр тодорхойлогдох механик цэвэр өсөлт гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлогдож байдаг. Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж, хөдөө орон нутгаас Нийслэл хотод шилжин ирэгсдийн тоо тогтвортой байгаагаас шалтгаалан хүн амын өсөлтөд ердийн өсөлтийн эзлэх хувийн жин жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Хүснэгт 3. Дүүргийн хүн амын ердийн болон механик өсөлт

	Шилжин ирсэн хүн ам	Шилжин явсан хүн ам	Механик өсөлт	Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент	Төрсөн хүүхэд	Нас барсан хүн	Ердийн өсөлт	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент
2011	11 895	8 289	3 606	19.1	4 452	1 051	3 401	18.0
2012	10 707	9 588	1 119	5.8	5 002	1 006	3 996	20.8
2013	14 892	12 443	2 449	12.5	5 371		5 371	27.3
2014	15 315	12 674	2 641	12.9	5 826	1 008	4 818	23.6
2015	15 309	12 505	2 804	13.5	5 716	984	4 732	22.8
2016	12 992	10 967	2 025	9.6	5 769	949	4 820	23.0
2017	17 430	15 068	2 362	10.8	6 065	1 086	4 979	22.9

Баянгол дүүрэгт 2017 онд 17430 хүн албан ёсоор шилжин ирж, 15068 хүн албан ёсоор шилжин явсан байна.

2017 онд 6065 хүүхэд шинээр мэндэлсэнээс 3194 нь буюу 52.7 хувь нь хүү, 2871 нь буюу 47.3 хувь нь охин байна.

Амаржсан эхийн насны бүлгээр авч үзвэл 19 хүртэлх настай 3.2 хувь, 20-24 настай 20.6 хувь, 25-29 настай 32.9 хувь, 30-34 настай 24.5 хувь, 35-39 настай 14.7 хувь, 40-44 настай 3.8 хувь, 45-аас дээш настай 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Нийт амаржсан эхийн 74.7 хувь буюу 4095 нь диплом болон бакалаврын дээд боловсролтой, 21.6 хувь буюу 1181 нь бүрэн дунд, 1.1 хувь буюу 61 нь магистр, 0.9 хувь буюу 51 нь тусгай мэргэжлийн дунд, 0.7 хувь буюу 41 нь доктор, 0.4 хувь буюу 19 нь техник мэргэжлийн дунд, 0.3 хувь буюу 15 нь суурь, 0.2 хувь буюу 11 нь боловсролгүй, 0.1 хувь буюу 6 нь бага боловсролтой байна.

2017 онд 1086 хүн нас барсан нь нийслэлд нас барсан нийт хүний 14.3 хувийг эзэлж байна.

Нас барсан хүн амын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байдаг ба нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн гол шалтгаан нь болж байна.

Зураг 2. Хүн амын дундаж наслалт, нийт дүнгээр



Зураг 3. Хүн амын дундаж наслалт, хүйсээр




2017 онд хүн амын дундаж наслалт Улсын хэмжээнд 69.9, Улаанбаатар хотод 71.5 болсон байна. 2012 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт улсын дунджаас 1.5 жилээр илүү байсан бол 2017 оны байдлаар 1.6 жил болж өсчээ.

Дүүргийн нийт хүн амын 63.0 хувь нь 34 хүртэлх насны залуучууд байгаа ба 2017 онд тус дүүрэгт 6065 хүүхэд төрсний 3196 нь буюу 52.7 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 4. Дүүргийн суурин хүн амын нас, хүйсийн бүтэц

	2013 он		2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
0-4	22 297	11 049	24 672	12 027	28 635	13 880	28 780	14 052	29 665	14 322
5-9	15 914	7 906	17 584	8 755	19 435	9 559	21 381	10 535	23 698	11 683
10-14	13 154	6 540	12 359	6 086	11 654	5 721	11 938	5 802	13 726	6 728
15-19	13 479	6 933	13 468	6 767	12 790	6 443	12 163	6 047	12 053	5 972
20-24	19 806	10 760	17 908	9 666	16 602	8 964	15 949	8 541	14 464	7 660
25-29	22 174	12 363	23 402	12 827	23 135	12 483	23 856	13 087	22 921	12 690
30-34	19 369	10 664	20 500	11 128	19 469	10 384	21 798	11 787	22 935	12 314
35-39	17 119	9 083	18 303	9 874	16 333	8 718	17 588	9 526	18 115	9 702
40-44	14 751	7 845	16 074	8 612	14 697	7 935	15 772	8 734	16 182	8 947
45-49	13 054	7 102	13 214	7 232	11 955	6 495	12 520	6 986	12 943	7 232
50-54	10 178	5 556	10 333	5 782	10 052	5 578	10 673	6 046	10 992	6 232
55-59	6 750	3 846	7 494	4 370	7 716	4 491	7 946	4 669	8 691	5 011
60-64	4 421	2 570	4 786	2 820	4 621	2 826	5 068	3 114	5 605	3 487
65-69	3 079	1 810	3 464	2 079	3 496	2 129	3 498	2 163	3 763	2 363
70+	4 618	2 707	5 337	3 178	5 073	3 088	5 348	3 266	5 631	3 480
Дүн	200163	106734	208898	111203	205663	108694	214278	114355	221384	117823

Зураг 4. Хүн амын нас, хүйсийн суварга /2010, 2017 оны жилийн эцэс/




Баянгол дүүргийн хүн амын нас хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 2010 онд 88.5 байсан бол 2017 онд 87.9 болж буурсан байна. Энэ нь хүн амын нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа, мөн хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн дунд эмэгтэйчүүд илүү байгаатай холбоотой болно. 2010, 2017 оны нас хүйсийн суваргаас харахад 0-14 насанд 100 эмэгтэй хүүхдэд ногдох эрэгтэй хүүхдийн тоо давамгайлж байгаа боловч нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 5. Хүн ам зүйн ачаалал, дүүргийн дүнгээр, 2010-2017 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
0-15 насны хүн ам	44 699	47 421	50 343	53 903	57 258	62 131	64 410	67 089
60 ба түүнээс дээш насны хүн ам	10 605	12 134	12 446	12 118	13 587	13 190	13 914	14 999
16-59 насны хүн ам	129 800	132 556	129 825	134 142	138 053	130 342	135 954	139 296
Хүн ам зүйн ачаалал	42.6	44.9	48.4	49.2	51.3	57.8	57.6	58.9


16 хүртэлх насны хүүхэд болон 60 ба түүнээс дээш насны өндөр настай хүн амын нийлбэрийг 16-59 насны хүн амд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг хүн ам зүйн ачаалал 2017 оны байдлаар 58.9 болж өмнөх оноос 1.3 пунктээр өссөн байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн бүр 59 хүнийг тэжээж байгаагийн 48 хүүхэд, 11 нь хөдөлмөрийн нас хэтэрсэн ахмадууд байна.

Зураг 5. Хүн ам зүйн ачаалал, хороогоор, 2017 он



2017 оны жилийн эцсийн байдлаар Баянгол дүүрэгт 60-аас дээш насны 14999 өндөр настан оршин сууж байгаагийн 37.8 хувь буюу 5669 нь эрэгтэй, 62.2 хувь нь 9330 нь эмэгтэйчүүд байна.

Зураг 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шалтгаанаар



2017 оны жилийн эцэст Баянгол дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 4819 иргэн амьдарч байгаа нь өмнөх оноос 136 хүнээр (2.9%) буурчээ.

Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 610 нь буюу 12.7 хувь нь 0-17 насны хүүхэд байна.

Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хүйс, хороогоор

	2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Бүгд	0-17 насны хүүхэд	Бүгд	0-17 насны хүүхэд	Бүгд	0-17 насны хүүхэд	Бүгд	0-17 насны хүүхэд
Бүгд	4 827	469	4 764	550	4 693	584	4819	610
1	296	20	302	28	277	27	316	41
2	206	20	238	24	215	20	217	14
3	202	10	154	11	259	29	273	27
4	332	23	237	26	288	28	326	41
5	174	14	191	23	174	14	183	38
6	332	25	341	30	309	44	355	40
7	262	18	291	18	283	17	269	28
8	231	32	235	32	205	44	211	41
9	169	12	173	12	162	15	152	21
10	296	21	328	27	293	45	260	21
11	139	13	143	13	143	21	143	21
12	221	21	215	22	176	28	249	20
13	124	13	131	13	141	19	93	11
14	110	8	110	8	113	11	133	11
15	97	11	109	12	90	13	92	13
16	301	22	280	20	279	20	268	21
17	149	24	128	24	119	26	197	29
18	102	21	99	22	125	33	119	31
19	167	12	167	12	167	12	106	16
20	149	47	175	23	144	24	180	30
21	267	39	253	37	261	43	288	40
22	242	22	205	22	205	29	210	32
23	259	21	259	91	265	22	179	23

2017 онд хагас өнчин хүүхдийн тоо 831 болж өмнөх оноос 56(6.3%) хүүхдээр , бүтэн өнчин хүүхдийн тоо 139 болж өмнөх оноос 10 (6.7%) хүүхдээр тус тус буурчээ. Хагас өнчин хүүхдүүдийн 398 нь (47.9%) эмэгтэй, бүтэн өнчин хүүхдүүдийн 67 нь (48.2%) эмэгтэй хүүхэд байна.

Нийт өнчин хүүхдийн 14.3 хувь нь бүтэн өнчин, 85.7 хувь нь хагас өнчин хүүхэд байгаа ба насны бүлгээр авч үзвэл 76 нь (7.8%) 0-4 насны, 239 нь (24.6%) 5-9 насны, 335 нь (34.5%) 10-14 насны, 320 нь (33.1%) 15-17 насны хүүхэд байна.

Хүснэгт 7. Өнчин хүүхдийн тоо, дүүргээр

Хороо	Бүтэн өнчин хүүхдийн тоо				Хагас өнчин хүүхдийн тоо			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Дүүргийн дүн	140	156	149	139	1029	976	887	831
1	14	13	16	9	44	44	35	27
2	4	6	8	3	39	29	28	18
3	3	3	3	3	44	46	41	42
4	10	14	12	14	51	64	55	46
5	2	2	0	2	47	41	36	35
6	11	16	14	11	55	49	57	52
7	11	8	8	7	53	44	45	58
8	4	6	7	6	29	27	23	16
9	4	5	2	3	28	19	39	29
10	4	8	8	8	60	60	31	31
11	6	12	11	11	50	53	52	54
12	4	3	3	1	39	38	33	36
13	2	2	2	1	30	33	33	27
14	0	0	1	0	15	17	26	22
15	2	1	2	2	14	14	15	13
16	3	5	5	9	30	31	30	33
17	5	7	7	4	30	41	32	40
18	3	4	3	3	27	21	29	12
19	2	2	2	3	13	15	15	16
20	8	8	8	6	52	11	5	10
21	8	7	12	13	116	119	126	126
22	15	12	6	10	89	93	42	44
23	15	12	9	10	74	67	59	44


БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Баянгол дүүрэгт 2017 оны байдлаар Улаанбаатар хотын нийт өрхийн 15.2 хувь буюу 58756 өрх оршин сууж, нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.8 болсон байна. Нийт өрхийн тоо 2016 оныхоос 515 өрхөөр буюу 0.9 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Өрхийн тоо, хороогоор

Хороо	2012	2013	2014	2015	2016	2017
Дүүргийн дүн	49 683	52 406	55 536	57 981	58 241	58 756
1	4 185	5 185	5 348	5 379	5 244	5 015
2	1 842	1 882	2 104	2 102	2 126	2 135
3	1 720	1 728	2 190	2 555	3 098	3 588
4	3 296	3 502	4 888	4 921	5 153	5 297
5	2 305	2 358	2 622	2 620	2 652	2 760
6	4 252	4 308	4 428	4 528	4 550	4 580
7	2 772	3 032	3 065	3 418	3 463	3 419
8	2 659	2 720	2 940	3 340	3 384	3 199
9	1 628	1 637	1 648	1 925	1 943	1 872
10	2 094	2 198	2 218	2 244	2 250	2 174
11	1 613	1 718	1 862	1 825	1 759	1 733
12	2 678	2 793	2 696	2 827	2 802	2 754
13	1 020	1 098	1 115	1 105	1 064	1 138
14	1 248	1 135	1 150	1 115	1 036	1 091
15	1 255	1 256	1 246	1 145	1 127	1 176
16	1 872	1 875	1 854	1 840	1 833	1 879
17	2 154	2 598	2 696	2 718	2 700	2 696
18	2 432	2 446	2 511	2 924	2 720	2 820
19	1 463	1 484	1 538	1 558	1 552	1 559
20	1 963	2 103	2 160	2 216	2 248	2 324
21	1 822	1 905	1 899	1 937	1 930	1 903
22	1 979	1 961	1 904	2 259	2 194	2 206
23	1 431	1 484	1 454	1 480	1 413	1 438

Зураг 7. Баянгол дүүргийн өрхийн тоо, дундаж ам бүл



Нийт өрхийн 1056 нь буюу 1.8 хувь нь 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх байна. Баянгол дүүрэгт ганц бие өндөр настай 286 хүн, мөн тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай 4 хүн амьдарч байна.

Хүснэгт 9. Өрхийн зарим үзүүлэлт

Төрөл	2014	2015	2016	2017
18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх	1047	1744	1290	1056
Ганц бие өрхийн тоо, бүгд	2451	2222	2187	1682
Үүнээс эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй	419	380	307	213
эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй	2032	1842	1880	1469
Ганц биеэр амьдарч буй ахмад настай өрхийн тоо	145	127	213	286
Үүнээс эрэгтэй(60 ба түүнээс дээш настай)	51	46	74	96
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	94	81	139	190

2017 оны байдлаар нийт өрхийн 2.9 хувь нь өрх толгойлсон ганц бие өрхүүд байна. Ийм өрхүүдийн 87.3 хувь нь эмэгтэй, 12.7 хувь нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрх байна.